



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 03 өдөр

Дугаар А/49

Мөрөн сум

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн
салбар зөвлөлийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 25 дугаар зүйлийн 25.1.7, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хорооны 2015 оны 4 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийг доорх бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Салбар зөвлөлийн дарга: Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын бодлого үйл ажиллагааг зохион
байгуулах ахлах мэргэжилтэн

Аймгийн үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга

“Хөвсгөл зам” ХХК-ийн Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн асуудал
хариуцсан ажилтан

“Хөвсгөл дулааны станц” ТӨХК-ий Үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга

Бизнес эрхлэгчийн төлөөлөл:

“Асрамж, халамж хамтын ажиллагаа” Төрийн бус байгууллага

Нарийн бичгийн дарга: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын
Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн
асуудал хариуцсан мэргэжилтэн

2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг зөвлөлийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2019 оны 04 дүгээр сарын 04-ны өдрийн А/148 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар) -д үүрэг болгосугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2023

6710010009